



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 05 сарын 04 өдөр

Дугаар Б/33

Ховд

Б.Баярсүхийг ажилд томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2016 оны 05/6389 тоот албан бичгээр хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь хянагдаж ирсэн Баатаржавын Баярсүхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргаар 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Б.Баярсүхийг Монгол улсын Засгийн газрын 2020 оны 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ"-ний ТЗ-10-4 дэх шатлал 1035204 төгрөг /Нэг сая гучин таван мянга хоёр зуун дөрвөн/-өөр цалинжуулж, зэрэг дэвийн нэмэгдлийг 30 хувиар, Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 10 хувиар тус тус үндсэн цалингаас тооцож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн албаны дарга бөгөөд ахлах нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-д зөвшөөрсүгэй.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Б.Баярсүхэд үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД